



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА САНДАГИЙН
БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.06.18 № 31-1/69
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264002760



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.06.17 № ХЭГ/2153
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай**

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт ¹ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265007124

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“7.ХЭЛЭЛЦСЭН нь: Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2026.06.17 № 01/7509

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хууль, тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.

Хүндэтгэсэн



З.МЭНДСАЙХАН

9761001018



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.06.17 № 1/3264

танай 2026.06.17 -ны № 01/7508 -т

**САНГИЙН САЙД
З.МЭНДСАЙХАН ТАНАА**

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



С.АМАРСАЙХАН

ХЗДХЯ-ны А5
152641 97



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.06.17 № 1/3265

танай 2026.06.17 -ны № 01/7507 -т


**САНГИЙН САЙД
З.МЭНДСАЙХАН ТАНАА**

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль
тогтоомжийн тухай хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19^{1.1}
дэх хэсэгт зааснаар Хууль тогтоомжийн тухай
хуулийн шаардлагыг хангасан байна.



С.АМАРСАЙХАН

ХЗДХЯ-ны А5
152641 9



Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт иргэн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүрэгтэй гэж тус тус заасан.

Монгол Улсын нэгдэн орсон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Тамхины хяналтын суурь конвенцын 2, 3 дугаар зүйлд оролцогч улс нь тамхины хэрэглээ, дам тамхидалт болон түүнтэй холбоотой сөрөг нөлөөллөөс хүн амыг хамгаалах зорилгоор үндэсний хууль тогтоомжийн хүрээнд нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд үүрэгтэй болохыг тодорхойлсон.

Түүнчлэн Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн тогтворжуулах татварын орчин болон чөлөөт бүсэд мөрдөгдөх татварын тусгай дэглэмийг тогтоохоос бусад тохиолдолд татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй гэж заасан. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 9-д татварын бодлого нь Сангийн сайдын эрхлэх асуудалд хамаарахаар заасан зэрэг нь хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон баталсантай холбогдуулан “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 117 дугаар тогтоолыг баталсан.

Тус тогтоолоор худалдааны түр хэлэлцээрийн хүрээнд тамхи агуулсан янжуур болон бусад тамхины гаалийн тарифыг тэглэсэнтэй холбогдуулан нийтийн эрүүл

мэнд, эдийн засаг, улсын төсөв, татварт үзүүлэх нөлөөллийн талаар дүн шинжилгээ хийх, гаалийн тарифын бууралтыг нөхөх, тамхины онцгой албан татварын зохистой түвшнийг тогтоох тооцооллыг боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Тухайлбал, худалдааны түр хэлэлцээрийн хүрээнд тамхи, тамхин бүтээгдэхүүний импортын гаалийн тариф "0" хувь болсноор импортын өртөг багасах, зах зээл дэх үнэ буурах, улмаар хэрэглээ нэмэгдэх эрсдэл үүсэхээр байна. Цаашлаад улсын төсөвт төвлөрөх онцгой албан татварын орлого тодорхой хэмжээгээр буурах нөхцөл бүрдэх бөгөөд үүнийг татварын бодлогын зохицуулалт хийж нөхөх шаардлагатай байна.

Иймд дээрхийг үндэслэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзлээ.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг дөрвөн зүйлтэй байхаар боловсруулна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тамхи, тамхин бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулахдаа биет нэгжид болон үнээс хувиар тооцож хосолсон хэлбэрээр тогтоох зохицуулалтыг, 2 дугаар зүйлд Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн гарчигт нэмэлт оруулах, 3 дугаар зүйлд хамрын тамхины биет хэмжээнд ногдуулах онцгой албан татварыг чөлөөлөх, 4 дүгээр зүйлд хууль дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар, гарах үр дүн

Хуулийн төсөл батлагдсанаар тамхины импортын гаалийн тарифын бууралтаас үүдэн улсын төсөвт учирч болох орлогын бууралтыг тодорхой хэмжээгээр нөхөх боломж бүрдэх бөгөөд төсвийн орлогын тогтвортой байдал хангагдана.

Түүнчлэн тамхи, тамхин бүтээгдэхүүний жижиглэн худалдаалах үнэд татварын бодлогоор нөлөөлөх замаар хэрэглээний өсөлтийг хязгаарлах, тамхины хэрэглээ нэмэгдэх эрсдэлийг бууруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Хууль гарсантай холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулсан бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

---o0o---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон баталсантай холбогдуулан 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 117 дугаар тогтоолыг баталсан.

Тус тогтоолоор тамхи, тамхин бүтээгдэхүүний гаалийн тарифыг тэглэсэнтэй холбоотойгоор татвар, төсөв, нийгэм, эдийн засаг, нийтийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тооцож, шаардлагатай хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Худалдааны түр хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд тамхи, тамхин бүтээгдэхүүний өртөг буурч, зах зээлийн үнэ хямдрах, хэрэглээ нэмэгдэх, улмаар улсын төсвийн онцгой албан татварын орлого буурах эрсдэлтэй.

Иймд төсвийн орлогын тогтвортой байдлыг хангах, тамхины хэрэглээг татварын бодлогоор зохицуулах зорилгоор Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг холбогдох хууль тогтоомжийн төслийн хамт боловсрууллаа.

Хуулийн төслөөр тамхи, тамхин бүтээгдэхүүнд онцгой албан татварыг хосолсон хэлбэрээр ногдуулах, мөн үнэд суурилсан татварын хувь хэмжээг тодорхойлон зохицуулахаар тусгасан болно.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр соёрхон баталсан. Хэлэлцээрт Монголын тал 300 гаруй нэр төрлийн барааг гишүүн орнуудад экспортлоход тарифын хувь хэмжээг "0" хувь байхаар тохирсон.

Тус хэлэлцээр нь худалдааны урсгалыг нэмэгдүүлэх, экспортын боломжийг өргөжүүлэхэд эерэг нөлөөтэй хэдий ч хэлэлцэн тохирсон барааны жагсаалтад тамхи, тамхин бүтээгдэхүүнийг хамруулсан нь уг бүтээгдэхүүний өртөг буурч, зах зээлийн үнэ хямдрах нөхцөл бүрдэн хэрэглээ нэмэгдэх, улсын төсөвт төвлөрөх гаалийн албан татварын орлого буурах эрсдэлийг бий болгож байна.

Улмаар Улсын Их Хурлаас хэлэлцээр батлагдсантай холбогдуулан "Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" 2025 оны 117 дугаар тогтоолыг баталсан. Тус тогтоолд тамхи, тамхин бүтээгдэхүүний гаалийн тарифыг тэглэсэнтэй холбоотойгоор төсөв, татвар, нийгэм, эдийн засаг, нийтийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тооцож, холбогдох хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан болно.

Иймд тогтоолыг хэрэгжилтийг хангах хүрээнд төсвийн орлогын тогтвортой байдлыг хангах, тамхины хэрэглээг татварын бодлогоор зохицуулах зорилгоор Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд тамхи, тамхин бүтээгдэхүүнд онцгой албан татварыг биет нэгж болон үнийн хувиар тооцох хосолсон хэлбэрээр ногдуулах, импортын тамхинд гаалийн үнэд суурилсан хувь хэмжээг тогтоох зохицуулалтыг тусгаж, Монгол Улсын Үндсэн хууль, Татварын ерөнхий хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Онцгой албан татварын тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулсан болно.

Мөн хуулийн төслийн хамт "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулахаар "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Онцгой албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг:

“5.5.Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 2, 3-т заасан бараанд онцгой албан татвар ногдуулахдаа биет нэгжид болон Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэж борлуулсан үнэ, эсхүл импортын гаалийн үнээс хувиар тооцож хосолсон хэлбэрээр тогтооно.”

2/6 дугаар зүйлийн 6.11 дэх хэсэг:

“6.11.Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 2, 3-т заасан барааны импортын гаалийн үнээс дараах хувиар онцгой албан татвар ногдуулна:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Ногдуулах онцгой албан татварын хувь
1	Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи	30
2	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи	30
	Үүнээс: Хамрын тамхи	20

2 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн гарчгийн “биет нэгж” гэсний дараа “, үнэ” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “хамрын тамхи” гэснийг “хамрын тамхийг энэ хуулийн 6.1 дэх хэсгийн 7-д заасан хэмжээгээр” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ"-ний 24 дүгээр бүлгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

24	24.01		Түүхий тамхи; тамхины хаягдал.	30
	24.02		Тамхи эсвэл тамхи орлуулагч агуулсан сигар, үзүүрийг нь тайрсан сигар (cheroots) болон нарийн ороосон сигар (сигарилл) болон янжуур.	0
	24.03		Боловсруулсан бусад тамхи болон тамхи орлуулагч; "нэгэн төрлийн болгосон" буюу "сэлбэгдсэн" тамхи; тамхины ханд болон охь.	0
	24.04		Тамхи, дахин боловсруулсан тамхи, никотин агуулсан эсвэл тамхи, никотин орлуулагч агуулсан, асаахгүйгээр сорж татах зориулалттай бүтээгдэхүүн; хүний биед никотин өгөх зориулалттай, никотин агуулсан бусад бүтээгдэхүүн.	5
		2404.11		Тамхи эсвэл дахин боловсруулсан тамхи агуулсан:

2.Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС**

№	Овог, нэр	Албан тушаал	Утасны дугаар
1	Загджавын Мэндсайхан	Сангийн сайд	
2	Бат-Ирээдүйн Анар	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	99078437
3	Чойгүнсэнгийн Чимидсүрэн	Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга	99117344
4	Даринчулууны Эрдэнэтуяа	Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга	94005933
5	Жаргалсайханы Төрболд	Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн	88834552
6	Чимэдийн Мөнхшүр	Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн	99054697
7	Рэгзэнгийн Мягмаржав	Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга	96008487
8	Чойдоржийн Чимгэрэл	Гаалийн ерөнхий газрын Барааны ангиллын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	99078054